

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2020 ОНЫ 05 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нэг: Нутгийн удирдлага зохион байгуулалтын талаар: Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг даргад 33 өргөдөл бичгээр хүлээн авч, 23 өргөдлийг шийдвэрлэж, 10 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт 10 өргөдөл бичгээр хүлээн авч, 9 өргөдлийг шийдвэрлэж, 1 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж өргөдөл гомдлын шийдвэрлэлт 74.1 хувьтай байна.

Угтах үйлчилгээ-Иргэдийн санал, хүсэлт, гомдол, талархал хүлээн авах 7043-1111 төв"-д 1 сувгаар 14 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 12, биечлэн 2 санал хүсэлт ирүүлснээс гомдол 3, санал хүсэлт 10, шүүмжлэл 1 тус тус бүртгэж холбогдох хэлтэс тасгийн дарга нарт шилжүүлж, 13 иргэний санал хүсэлтэд хариу өгч, шийдвэрлэлт 92,8 хувьтай байна. Үүнд: Орчны эрүүл ахуйн асуудлаар 3, боловсролын асуудлаар 1, бусад асуудлаар 7 иргэн тус тус хандаж, шийдвэрлэлт 1-10 хоногтой 13, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа санал хүсэлт 1 байна.

Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдлийг бүртгэгдээгүй, Засгийн газрын 1111 төвд тайлант сард санал хүсэлт ирээгүй болно.

Монгол Улсын Төрийн албаны Зөвлөлийн гишүүн Б.Идэрчулуунаар ахлуулсан зөвлөн туслах ажлын хэсэг орон нутгийн төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж буй байдал, Төрийн албаны тухай хууль, шинэтгэлийн бодлого, стратеги, чадахуйн зарчмын хэрэгжилттэй танилцах, хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаанд зөвлөн туслах, тулгамдаж буй асуудлын талаар уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, санал хүсэлтийг сонсох ажлаар Ховд аймагт ажиллав.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Маргаан хянан шалгах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Эрдэнэхишиг, шинжээч Э.Мөнхгэрэл, мэргэжилтэн Р.Жавзандулам, Хүний нөөцийн удирдлага, аудитын газрын мэргэжилтэн Б.Чойжилгарав нар ажиллалаа.

Ажлын хэсэг аймгийн Засаг даргын Тамгын газар болон Жаргалант сум, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол, соёл урлагийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Санхүүгийн хяналт, аудитын алба, Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагаатай танилцан зөвлөн тусалж, тулгамдаж буй асуудал, бэрхшээл юу байгаа талаар санал хүсэлтийг нь сонсож, байгууллагуудын удирдах албан тушаалтан, ЭБАТ-ыг оролцуулан сургалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөл нь НҮБ-ын төслийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөлтэй хамтран орон даяар ажиллаж, Төрийн албаны тухай хуулийг сурталчлах,

хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан талаар болон практик дадлага сургалт, уулзалт хэлэлцүүлгийн өмнөх оныхоос ялгаатай нь 2020 онд тавигдаж байгаа зорилтууд болон өмнөх онд яригдаагүй байсан сэдвүүдээр мэдээлэл хийж байгаагаараа онцлог байв.

Мөн ажлын хэсэг Алтай, Манхан, Мөст, Мянгад, Мөнххайрхан, Дарви, Дуут, Дөргөн, Зэрэг, Цэцэг, Чандмань, Эрдэнэбүрэн сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Нарийн бичгийн дарга, Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй цахим уулзалт хийж, санал хүсэлтийг нь сонсож, цаг үеийн ажлын талаар мэдээ мэдээлэл хийв.

Төрийн албаны тусгай шалгалтын талаар:

Коронавирусын цар тахлын нөхцөл байдал урьдчилан төсөөлөх боломжгүй, үл мэдэгдэх олон сорилтууд байгааг харгалзан төрийн байгууллагын хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг шуурхай хангах үүднээс сул орон тоог нөхөх, хүний нөөцийг бүрдүүлэх тусгай шалгалт, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах шаардлага үүссэн учраас 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн "Төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 141 дүгээр тогтоолыг баталсан.

Орон нутагт төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудад гарсан 80 гаруй сул орон тоог нөхөхөөр хуваарь гаргаж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн, төрийн албаны тусгай шалгалтыг хялбаршуулсан хэлбэрээр зохион байгуулж эхлээд байна. Тусгай шалгалтад бүртгүүлэх иргэд цөөн байгаа төдийгүй 5 дугаар сард хялбаршуулсан хэлбэрээр зохион байгуулсан 3 удаагийн шалгалтаар 9 байгууллагын 19 сул орон тоог Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn цахим хуудсанд байршуулж зарлуулахад 5 ажлын байранд өрсөлдөхөөр 7 иргэн бүртгүүлж, ажлын байранд 5 иргэнийг тухайн сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсэн шийдвэрийг Төрийн албаны салбар зөвлөлөөс гаргаж, холбогдох газруудад хүргүүлэв.

Тусгай шалгалтад бүртгүүлэх иргэд цөөн байгаа нь аймгийн төрийн албаны нөөц чамлалтай байгааг харуулж буй боловч нөгөө талаас төрийн албанд орох хүсэлтэй залуус олон байна. Иймд Төрийн албаны ерөнхий шалгалт зохион байгуулж орон нутагт төрийн албаны нөөц бүрдүүлэхэд анхаарах шаардлагатай байгааг талаар Төрийн албаны зөвлөлийн зөвлөн ажлын хэсэгт уламжиллаа.

Аймгийн Онцгой комиссын ажлын талаар: Аймгийн Онцгой комисс тайлант сард 2 удаа хуралдаж Ховд аймагт үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай 10 асуудлыг хэлэлцэн, холбогдох асуудлаар 2 шийдвэр, Онцгой комиссын даргын 1 тушаал, үүрэг хүргүүлэх болон холбогдох албан бичиг, баримтыг гаргаж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Аймгийн Сонгуулийн хорооноос зохион байгуулж буй "Мэдээлэл технологийн даамал"-ын сургалтыг 2020 оны 05 дугаар сарын 24-27-ны өдрүүдэд зохион байгуулж, КОВИД-19 халдварт өвчний үед дагаж мөрдөх заавар журмын дагуу хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

Булган сумын Булган боомтоор уул уурхайн бүтээгдэхүүн экспортын тээвэрлэлтийг эхлүүлэхтэй холбоотойгоор аймгийн Онцгой комиссын даргын 2020 оны 19 дүгээр тушаалаар томилогдсон ажлын хэсэг бэлтгэл ажилтай газар дээр нь танилцаж “Уул уурхайн бүтээгдэхүүн экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөл байдалд зохион байгуулах түр журам”-ын дагуу 2020 оны 05 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд Хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Аймгийн шуурхай штаб 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдөр хуралдаж байгууллага бүрээс эргүүл жижүүрийг ажиллуулан амны хаалтгүй гадуур явж байгаа иргэдэд хяналт тавьж, амны хаалт зүүх шаардлага тавин ажиллаж байна.

Аймгийн Онцгой комиссын даргын 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 17 дугаар тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулан “Маскаа зүүцгээе” аяныг эхлүүлж тогтоолын хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. “Маскаа зүүцгээе” аяны хүрээнд орон нутгийн хэмжээнд “COVID-19” халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд ард иргэдийг маск зүүж хэвшүүлэх, маск зүүгээгүй иргэдэд хүн ам олноор цуглардаг худалдаа, үйлчилгээний газрууд, банк санхүүгийн байгууллагаар үйлчлэхгүй байх талаар иргэд олон нийтэд чиглэсэн ухуулга сурталчилгаа, сэрэмжлүүлэг, мэдээллийг орон нутгийн телевизээр ард иргэдэд хүргэн ажиллаж байна.

Хоёр: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд: Орон нутгийн төсвийн байгууллагуудын 5 дугаар сард улсын төсвийн санхүүжилт 30840,8 сая төгрөг ирэхээс 29268,9 сая төгрөг ирж, цалин хөлс, тогтмол зардлуудыг хянаж, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүллээ. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймагт олгох орлогын шилжүүлгийн 4057,3 сая төгрөгийн санхүүжилтээс 2485,0 сая төгрөгийн санхүүжилт ирж аймаг, сумдад хуваарийн дагуу олголоо.

Сумдын санхүүгийн дэмжлэгт 5956,7 сая төгрөг, аймгийн төвийн орон нутгийн төсвийн байгууллагуудад 3377,4 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтээс сургуульд 12236,8 сая төгрөг, цэцэрлэгт 6027,1 сая төгрөг, хүн эмнэлэгт 2519,1 сая төгрөг, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 216,6 сая төгрөг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 230,7 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон.

Сум, байгууллагуудаас ирүүлсэн төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлтийг хянаж, аймгийн Засаг даргын А/268 дугаар захирамжаар тус байгууллагуудын 5 дугаар сарын төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж, зохицуулалт хийж баазыг Сангийн яаманд хүргүүлж батлагдсан хуваарийн дагуу санхүүжилтийн эрхийг нээлгэлээ.

Аймаг орон нутгийн төсвийн багууллага болон аж ахуйн нэгжүүдийн 2019 оны санхүүгийн тайлан, нэгтгэл дүн мэдээ, мөн “Санхүүчдийг чадавхижуулах” хөтөлбөрийн хэрэгжилтийн дүнг гаргаж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэхээр хүргүүллээ.

Зэрэг, Дарви, Цэцэг, Булган, Үенч, Алтай, Мөст, Мөнххайрхан сумдад 5 дугаар сарын 18-21-ний өдрүүдэд, Ховд, Эрдэнэбүрэн суманд 5 дугаар сарын 22-ний өдөр, Манхан, Чандмань, Дөргөн, Мянгад суманд 5 дугаар сарын 26-наас 27-ний өдрүүдэд хэлтсийн дарга ТА-3 төслийн нэгжтэй хамтран сумын ОНХС-ийн 2019 оны ажлын дүн, 2020 оны ажлын төлөвлөлт, түүнийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд болон санхүү, бүртгэлийн ажилтнуудаас 2019 онд хэрэгжүүлсэн ажил, 2020 оны эхний 5 сарын ажлын дүнгийн тухай болон цаашид хэрэгжүүлэх ажлын бодлого чиглэлийн талаар мэдээлэл, зөвлөмж өгч сумын санхүүгийн албанд 1 ширхэг компьютерийг хүлээлгэн өглөө.

Аймгийн татварын хэлтсээс тооцоо хийж баталгаажуулсан 2019 оны иргэдийн төлсөн татвараас буцаан олгох 589.1 сая төгрөгийг 1356 хүнд олгож тооцоог бүрэн дуусгалаа. Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системд 5150 ширхэг зардлын ваучер бичиж, 1364.7 сая төгрөгийн зарлагын гүйлгээг зардлын ваучераар гүйцэтгэлээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор “SMS” МТ үйлчилгээг шинээр нэвтрүүлж төсвийн захирагч, нягтлан бодогч 300 гаруй хүнд тухайн сарын мэдээллээ оруулах талаар мессежээр чиглэл өгч, хэрэгжилтийг хангаж байна. Дээрх хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын албан шаардлагын дагуу улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж байгууллагын 2019 оны шилэн дансны мэдээллээ байршуулаагүй ААН-ийн мэдээллийг нөхүүлэн байршуулж зөрчил дутагдлыг арилгуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоолын дагуу Төрийн албаны цалингийн нэгдсэн системийг нэвтрүүлэхдээ холбоотой 6 сургагч багшийг аймгийн хэмжээнд бэлтгэж, төрийн албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах бусад мэдээллийг цалингийн нэгдсэн системд үнэн зөв байдлаар оруулах ажлыг 171 байгууллагаас 51 байгууллагад нэвтрүүлж байгаа нь хэрэгжилт 30 хувьтай байна.

Аймгийн ИТХ-ын даргын 03 дугаар сарын 27-ны өдрийн А/08 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж Мянган Угалзат ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлангийн өглөг, авлагын байдалд дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргаж тус байгууллагын ТУЗ-д танилцуулж хэлэлцүүлсэн.

Санхүүгийн Зохицуулах хорооны хяналт шалгалт, зохицуулалтын газрын даргын 2020 оны 4 дүгээр сарын 25-ны 9/1579 дугаар албан бичгийн дагуу Ховд аймагт бүртгэлтэй аймгийн төвийн 2, Манхан, Эрдэнэбүрэн сумын Хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж Дөргөн, Дарви, Үенч сумдын материалыг цахимаар авч дүнг нэгтгэн СТСХ-ийн даргын 2020 оны 05-р сарын 19-ны 5/838 дугаар албан бичгээр, мөн цахимаар хүргүүллээ.

Санхүүгийн зохицуулах хорооноос 2020 оны 04 сарын 14-нд олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр 6 төрлийн богино хэмжээний бичлэг

/анимейшн/ мэдээллийг ирүүлснийг 2020 оны 04 дүгээр сарын 15-аас эхлэн 05 дугаар сарын 05 хүртэл Ховд аймгийн иргэд, олон нийтэд сурталчилж цахим хуудас, телевиз, мэдээллийн самбараар түгээх ажлыг зохион байгуулсан. Даатгалын зуучлагчийн эрх авах шалгалтын бэлтгэл ажлыг хийж, шалгалтын материалыг цаасаар болон цахимаар СЗХ-нд хүргүүлж ажиллав.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 4 дүгээр сард Эрдэнэбүрэн, Дуут сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг хийлээ.

Мөн Ховд аймгийн Прокурорын газартай хамтран хорих 457 дугаар ангийн хоригдлуудын цалин хөлс олголтод хяналт шалгалт хийж, тайлан материалыг аймгийн Прокурорын газарт хүргүүлээ.

Эрдэнэбүрэн суманд хийсэн шалгалтаар сумын хэмжээнд 203 хүнтэй холбоотой 63,4 сая төгрөгийн зөрчил илрүүлж 32,3 сая төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт оруулахаар, 11,1 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгуулахаар, 0,8 сая төгрөгийг буцаан олгохоор, 19,1 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангийн дансанд оруулахаар тус тус шийдвэрлэж, улсын ахлах байцаагчийн 38 акт бичсэн.

Дуут суманд хийсэн шалгалтаар 167 хүнтэй холбоотой 44,9 сая төгрөгийн зөрчил илрүүлж 31,3 сая төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт оруулахаар, 11,3 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгуулахаар, 1,5 сая төгрөгийг буцаан олгуулахаар, 0,8 сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод оруулахаар тус тус шийдвэрлэж, улсын байцаагчийн 48 акт бичсэн.

Аймгийн Татварын хэлтэс нь 2020 оны 5 дугаар сарын НӨАТ-ийн тайланг 100 хувь, хүлээн авч, тайлант хугацаанд бүртгэгдсэн ААНБ-уудыг аймгийн Улсын бүртгэл болон Статистикийн хэлтэстэй тулгалт хийж Тахаст болон Tips программд бүртгэл хийлээ. Үүнд: ХХК 72, Нөхөрлөл 4, төрийн бус байгууллага 9, салбар 1, сан 1, хоршоо 4, нийт 92 аж ахуйн нэгж байгууллага бүртгэгдлээ.

Төрийн сангийн цахим сайтаар дамжуулан татварын орлогын хуулгыг өдөр бүр нэр, төрөл бүрээр татварын мэдээллийн сангийн боловсруулалт хийж, татварын данс андуурч орсон 20 татвар төлөгчтэй холбоотой 5 төрлийн татварын 24.4 сая төгрөгийг залруулах бичилт хийлээ.

Улс, аймаг, сум орон нутгийн төсөвт 2020 оны 05 сарын 28-ны байдлаар нийт 5580.8 сая төгрөг оруулахаас 5499.5 сая төгрөг орсон нь 98.5 хувьтай байна. Үүнээс улсын төсөвт 1318.4 сая төгрөг оруулахаас 1464.9 сая төгрөг орж 111.1 хувиар, аймгийн төсөвт 3488.5 сая төгрөг оруулахаас 3263.4 сая төгрөг орж 93.5 хувиар, сум орон нутгийн төсөвт 773.8 сая төгрөг оруулахаас 755.9 сая төгрөг орж 97.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хяналт шалгалтанд 1 татвар төлөгчийг хамруулж, татвар төлөгчийн гаалийн болон хөндлөнгийн мэдээллийг ашиглан шалгалт хийснээр шалгалтын явцад 19.7 сая төгрөгийн зөрчилд 2.1 сая төгрөгийн нөхөн татвар ногдуулж, хуулийн дагуу 0.8 сая

төгрөгийн торгууль, нийт 3.0 сая төгрөгийн нөхөн татвар торгууль, алданги ногдууллаа.

Аймгийн Статистикийн хэлтэс нь олон улсын өртөгийн зэрэгцүүлэлтийн үнийн судалгаа, хэрэглээний бараа үйлчилгээний үнийн судалгааг хийж, Үндэсний статистикийн хороонд графикт хугацаанд нь бүрэн дамжууллаа. 2020 оны хагас жилийн мал тооллогыг энэ сарын 25-31-ны өдрүүдэд орон даяар зохион байгуулж байгаатай холбоотой мал тооллогыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, тооллогын хяналтыг 5 дугаар сарын 27-29-ны өдрүүдэд Алтай, Үенч, Булган сумдад хийлээ.

Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааг Жаргалант сумын Бичигт, Цамбагарав багт, Булган сумын Бүрэнхайрхан, Дарви сумын Мөнгөн-аяга, Чандмань сумын Урдгол, Манхан сумын Тахилт багуудад тус тус зохион байгууллаа. Ажиллах хүчний судалгааг Үенч сумын Нарийнгол, Мянгад сумын Гахайт, Дарви сумын Дэлгэр, Чандмань сумын Тахилт багуудад хийгдэж байна.

Гурав: Хууль эрх зүйн салбарын хүрээнд: Захиргааны болон иргэний, эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны 3 шүүх хуралдаанд хариуцагчийг төлөөлж Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн оролцсон. Шийдвэрлэгдээгүй байгаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхээс шаардсан нотлох баримтуудыг нотлох баримтын шаардлага хангуулан хугацаанд нь гаргаж хүргүүлээ.

Шүүхийн шинжилгээний алба: Тус албанд хандаж 24 албан бичиг, шинжилгээ хийлгүүлэх тогтоол, захирамж 110 ирүүлснийг хүлээн авч, бүртгэн цаг тухайд нь шийдвэрлэж, байгууллагаас 29 бичиг боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлж ажиллав.

Эд эсийн шинжилгээг дамжуулж, блокыг дагалдах хуудсын хамт ШШҮХ-нд хүргүүлж хариуг албаны цахим khovd_nifs@yahoo.gov хаягаар авч ажиллаж байна.

Шүүх эмнэлгийн бүтцийн шинжилгээг 5 цогцост, гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 83, эд эсийн шинжилгээ 5, тусгай шинжилгээ 5, криминалистикийн шинжилгээ 8 тус тус хийж дүгнэлт гаргасан.

Гэмт хэргийн газрын үзлэгт криминалистикийн мэргэжилтэн, шинжээч нар 37 удаа оролцож, хэргийн газрын үзлэгээр гарын 59 ширхэг мөр, гутлын мөр 17, тээврийн хэрэгслийн мөр 10, биологийн гаралтай ул мөр 1, бичил мөр 2, эвдлэгч багажны мөр 1, бусад ул мөр, 46 эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэн, гарын хээний дардас 60, гарын мөр 16 авч АДИС-Папилон салбар станцад баяжилт хийлээ.

Албанаас гаргасан гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ, бүтцийн шинжилгээ, химийн шинжилгээ, биологийн шинжилгээ, криминалистикийн шинжилгээнүүдийн дүгнэлтүүд болон ирүүлсэн тогтоолуудыг тухай бүрт нь цахим санд оруулан ажиллаж байна.

Албаны үйл ажиллагаа, алба хаагчдын сахилга, ёс зүйтэй холбоотой мэдээлэл ирээгүй байна. Захиргааны шинжтэй 2 өргөдөл ирүүлснийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу өгч ажилласан.

Цагдаагийн газар: Тайлант сард иргэд, олон нийтийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдний хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, олон нийт, цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг өргөнөөр татан оролцуулах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Улсын хэмжээнд явагдсан “Байгалиа хамгаалъя”, “Аюулгүй ажиллагаа амьдралын баталгаа” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэрт салбар төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Цагдаагийн газрын нийт алба хаагчдыг хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд чиглэсэн арга хэмжээний чанар, хүртээмжийг сайжруулан давхардсан тоогоор аймгийн төв Жаргалант суманд үйл ажиллагаа явуулж буй 70 төрийн байгууллага, 10 төрийн бус байгууллага, 33 аж ахуйн нэгж, иргэдэд чиглэсэн ажил, арга хэмжээ зохион байгуулсан.

Хүүхэд, багачууд болон, иргэдийн дунд “Байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалъя” гар зураг, шүлгийн уралдааныг зарлаж, дүгнэлээ.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах чиглэлээр эрх бүхий байгууллага, албан тушаалтанд 18 удаагийн мэдэгдлийг хүргүүлж, 6 мэдэгдлийн хариуг авч, 5 мэдэгдлийн дагуу зохион байгуулсан ажлыг газар дээр нь шалгаж ажиллав.

Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журам зөрчин үйлдэгдэж буй хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэргийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад аюулгүй ажиллагааны талаар хууль дүрмийг сурталчлан таниулах, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, барилга угсралт, барилгын материалын үйлдвэр, тоног төхөөрөмж ашигладаг үйлдвэрийн хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг хэрхэн ханган ажиллаж байгаа байдалд хамтарсан шалгалт хийх зорилгоор төлөвлөгөө гаргаж, Цагдаагийн газрын дарга, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга нарын хамтран баталсан төлөвлөгөөний дагуу 20 аж ахуйн нэгжийн 26 барилга, угсралтын үйл ажиллагааг, 31 аж ахуйн нэгж, 5 иргэний 36 барилгын материалын үйлдвэрийн үйл ажиллагааг тус тус шалгаж ажилласан бөгөөд хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журам зөрчсөн 11 аж ахуйн нэгжийн зөрчлийг газар дээр нь арилгуулж ажилласан.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Мэргэжлийн хяналтын газартай хамтран мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сумдын ИТХ-ын дарга буюу Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дарга нарыг оролцуулан цахим хурал зохион байгуулж, Цагдаагийн газрын эрүүлжүүлэх, баривчлах байранд баривчлагдсан 32 этгээдэд “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”, Хулгайн гэмт

хэргээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр өдөрт 2 цагийн албадан сургалтыг 16 удаа зохион байгууллаа.

Орон нутгийн “Ховд”, “Олон ястны” телевиз, “Гэр бүлийн радио” 104, Тэмүүлэл fm 89.1-тэй хамтран байгууллагын үйл ажиллагаа болон улс, орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нэвтрүүлэг 1, зочны буюу ярилцах цаг 2, 11 мэдээ сурвалжлагийг бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэж, “Khovd.mn”, “Монцамэ”, “Khovdnews.mn” сайтад 3 удаагийн ярилцлага, мэдээлэл нийтлүүлээ.

Аймгийн хэмжээнд 2020 оны 04 дүгээр сарын 25-аас 05 дугаар сарын 25-ны хооронд 258 гомдол мэдээлэл хүлээн авсны 69 буюу 26,7 хувийг гэмт хэргийн шинжтэй, 189 буюу 73,3 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл эзэлж байна.

Бүртгэгдсэн 49 гэмт хэргийг төрлөөр нь ангилан үзвэл: Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 5, хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 4, хулгайлах гэмт хэрэг 5, мал хулгайлах 3, залилах гэмт хэрэг 5, завших 13, авто тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 2, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох 3, авто тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүй авч явах 1, хууль бусаар мод бэлтгэх 1, дээрэмдэх 1, хүчиндэх 3, татвараас зайлсхийх 1, хууль бусаар ан агнах 1, дарга, захирагч нь захирагчдаа хүч хэрэглэх 1,

Хүлээн авсан гомдол мэдээллийг төрлөөр нь авч үзвэл: Бусдын биед халдах 10, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 16, залилах 9, зам тээврийн осол 8, ЗХАБЖЗ 2, мал хулгайлах 3, ОНАТБА-35, завших 11, хулгайлах 1, дээрэмдэх 1, хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 23, хууль сахиулагчийг эсэргүүцэх 3, хүрээлэн байгаа орчны эсрэг 5, худалдаа үйлчилгээний журам зөрчсөн 7, хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 5, хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг 2, хууль бусаар ашигт малтмал хайх олборлох 1, амиа хорлох 1, цахим доромжлох гүтгэх 1, эдийн засгийн эсрэг 1, бусад 113 гомдол мэдээлэл тус тус хүлээн авч шийдвэрлэв.

Дээрх хугацаанд зөрчил гаргасан 145 хүнийг эрүүлжүүлж, 236 хүнийг 48.910.00 төгрөгөөр торгож, хурд хэтрүүлсэн болон согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 82 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасаж, 42 хүнийг 7-30 хоногийн хугацаагаар баривчлан ажиллав.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар нээлттэй, хаалттай хорих анги: Тус анги үйл ажиллагаандаа холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдлөг болгон ангийн хэвийн үйл ажиллагаа, хоригдол, хоригдогч нарын аюулгүй байдлыг хангах, тэдний дундаас гарч болзошгүй аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хоригдлыг нийгэмшүүлэх ажлын чиглэлээр төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус ангийн “Ёс зүйн салбар хороо”-оос Төрийн албаны болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйлчилгээний стандартыг жигд сахин хангуулахад чиглэсэн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлж

ажиллаж байгаа бөгөөд ёс зүйгүй харьцаа, авлига, хүнд суртлын талаар зөрчил гаргасан алба хаагч өнөөдрийн байдлаар гараагүй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2019 оны 11 дүгээр сарын 07-ний өдрийн А/197 дугаар тушаалаар батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад 2019-2020 онд зохион байгуулагдах сургалтын хөтөлбөр"-т заасны дагуу алба хаагчдын мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх, дадлагажуулах зорилгоор сургалтын хөтөлбөр, багшлах бүрэлдэхүүний хуваарийг ангийн даргаар батлуулан сургалтын төлөвлөгөөний дагуу танхимын болон танхимын бус хэлбэрээр хичээл сургалтыг зохион байгуулж, алба хаагчдыг бүрэн хамруулан ажиллав.

Шинэ төрлийн Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх эрсдлийг бууруулах зорилгоор Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2020 оны 01/01 дүгээр зөвлөмж, улсын онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн “Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажиллах тухай” А/28 дугаар тушаал гарсантай холбогдуулан өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажиллаж байгаа тул дадлага, сургуулилтыг ангийн даргын 2020 оны А/18 дугаар тушаалаар шуурхай штабыг байгуулж, дадлага сургуулилтад 28 алба хаагчийг хамруулж, амжилттай зохион байгуулсан.

Алба хаагчдын багаар ажиллах чадвар, хууль эрх зүйн мэдлэг, бие дааж суралцах чадвар олгох зорилгоор албан хэрэгцээнд өргөн хэрэглэгддэг хууль, дүрэм журмаар гарын авлага бэлтгэх уралдаан зарласан бөгөөд уралдаанд шалгарсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай цахим хууль, Хорих байрны дотоод журмыг ангийн захиргааны дэмжлэгтэйгээр CD болгон олшруулж алба хаагчдын хэрэгцээнд ашиглаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын даргын 2020 оны 2а/1977 дугаар албан бичгээр ирсэн үүргийн биелэлтийг хангах ажлын төлөвлөгөө боловсруулан албаны сургалтын хөтөлбөрт тодотгол хийж танхимын дараах сургалтуудыг зохион байгуулаад байна. 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдөр алба хаагчдад хэсэгчилсэн байдлаар Цаст-Алтай цогцолбор сургуулийн сэтгэл зүйч Г.Энхбаяр “Харилцаа болон Зөрчил маргааныг зохицуулах нь” сэдвээр 2 цагийн лекц, 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдөр алба хаагчдад хэсэгчилсэн байдлаар Ерөнхий боловсролын Лаборатори 1 дүгээр дунд сургуулийн багш С.Норолхоо “Монгол хэлний зөв бичих дүрэм”, “Монгол хэлний журамласан үгсийн тухай” сэдвүүдээр 2 цагийн сургалт, дасгал ажил, 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдөр тус ангийн хүний их эмч Б.Оргилболд “Халдварт болон халдварт бус өвчний тухай ойлголт” сэдвээр 1 цагийн хичээл сургалтыг тус тус зохион байгууллаа.

Тус ангийн тоо бүртгэлийн тасаг, ахлагчийн зөвлөл хамтран “Нэг нь нийтийн төлөө, нийт нь нэгний төлөө” уриан дор алба хаагчид, тасаг нэгжийн уялдаа холбоо, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, дотоод ажлыг эрчимжүүлэх аяныг 2020 оны

05 дугаар сарын 10-ны өдрөөс 06 дугаар сарын 04-ний өдөр хүртэл зохион байгуулан ажиллаж байна.

Ховд аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-457 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн үйл ажиллагаа хууль, журмын дагуу хэвийн явагдаж байгаа бөгөөд хоригдол, хоригдогч нарын дундаас ямар нэгэн гэмт хэрэг зөрчилгүй тайван байгаа болно.

Дөрөв: Нийгмийн бодлого салбарын хүрээнд:

Боловсролын чиглэлээр: Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн суралцагчдад элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлага зохион байгуулахад мөрдөх заавар бүрээр БСШУСЯ-ны сайдын 220 дугаар тушаалын хэрэгжилтийг 40 үзүүлэлтийн дагуу сургуулийн сурагчдын цахим хичээлийн хамрагдалт, чанар үр дүн, элсэлтийн ерөнхий шалгалтын давтлагын явц анги танхимын ариутгал халдваргүйтгэлийг эрүүл мэндийн байгууллага болон мэргэжлийн хяналтын байгууллагаас гаргасан хэрэгжилтийн үр дүнтэй танилцах зорилгоор хөдөөгийн 16 сумын сургуулиудад Жаргалант сумын 1, 2, 3, 6, 7, Цаст-Алтай, Прогресс, Лицей сургуулиудад 2020 оны 5 дугаар сарын 12-15-ний өдрүүдэд ажиллав. Ажиллах хугацаандаа захирал, менежер, эмч, сургуулийн нийгмийн ажилтан, ЭЕШ-д бэлтгэж буй 20 багштай уулзаж ЭЕШ-ын давтлагын явц, үр дүн, сурагчдын цахим хичээлийн хамрагдалт, анги дэвших болон төгсөлт зохион байгуулах бэлтгэл, ирэх хичээлийн жилийн бэлтгэл хангаж байгаа байдалтай танилцах, зөвлөн туслах зорилгоор БСУГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу ажиллалаа.

Бага ангийн багш сургалтын менежерүүдтэйгээ хамтран теле хичээл бэлтгэж Ховд телевиз, Ховд аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын facebook, “Ховд бага боловсрол” facebookгрупп, “Ховд бага менежерүүд” группээр тус тус байршуулж багш нарт хүргэж 7 хоног бүр ЕБС, цэцэрлэгийн ТВ цахим хичээлийг мэргэжлийн группэд байршуулж нээлттэй мэдээлж байна. Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн IY шат хэрэгжүүлж байгаа 18 сургуулиас Google form ашиглан хэрэгжилтийн судалгаа авч төсөл хэрэгжүүлэх нэгжид хүргүүлсэн.

“Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”, “Монгол хэлний сургалтын талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг бүх сургууль, цэцэрлэг, НТБ, соёлын байгууллагад хүргүүлэв.

Баруун бүсийн төв Ховд аймгийн онцгой байдлыг газраас Жаргалант сумын нутаг дэвсгэрт байрлах боловсролын байгууллагад Гамшгаас хамгаалах болон, Галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт норм нормативийн баримт бичгийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжийг хүргүүлж хамтран ажиллаж байна. Тус шалгалт 2020 оны 05 дугаар сарын 20-оос 06 дугаар сарын 02-ны өдрүүдэд үргэлжилнэ.

БСШУС яам, Дэлхийн зөн ОУБ-тай хамтран Үенч сумын хүүхдийн цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах төслийн суурь судалгаа, зураглалыг хийж хүргүүлэв. Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтны судалгааг мэргэжлээр нь гаргаж БСШУС яаманд хүргүүлээ. Мөн Дотуур байрны хүүхдийн

хоолны материал болон буцаалтын талаар яамнаас ирүүлсэн судалгааг 17 дотуур байр бүрээр гаргаж нэгтгэн хүргүүллээ.

Төрийн өмчийн цэцэрлэгүүдийн 5 настай 2164 хүүхдийн судалгааг нэрсээр гаргаж, “Дасгал ажлын дэвтэр”-ийг бүх сумдын багийн хүүхдүүд хүргүүлсэн төдийгүй Ховд СӨБ группээр дамжуулан цэцэрлэгүүдийн багш нарын арга зүйн туршлагыг солилцон ажиллаж байна. 5 дугаар сард Булган сумын 2 дугаар цэцэрлэг, Дөргөн, Алтай сумын цэцэрлэгийн багш нарын сайн туршлагыг түгээн ажиллав.

Zoom программ ашиглан хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй, суралцах бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй, хөгжлийн ялгаатай хүүхэдтэй ажиллах арга зүй сэдэвт сургалтуудыг зохион байгуулж сургуулиуд харилцан туршлагаа солилцлоо.

БМДИ-ээс боловсролын газрын мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулж буй онлайн сургалтад бүх мэргэжилтнүүдээ хамрууллаа. Сургалтын хүрээнд төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журмуудыг танилцууллаа. Мөн мэдээлэл харилцаа технологиос google form ашиглан мэдээ өгөгдөл цуглуулах, хүснэгтэн мэдээлэл, бичвэр боловсруулах програм дээр ажиллах, судалгааны цахим танилцуулга бэлтгэх аргачлалтай танилцлаа.

АНУ-д хэрхэн суралцах тухай АНУ-ын Элчин сайдын Яамны онлайн хуралд багш сурагч эцэг эхчүүдийг хамруулж, АНУ-ын Элчин сайдын Яамны тэтгэлэгт "Аксесс" хөтөлбөрт 9 дүгээр ангийн сурагчдыг хамруулж хичээлийг эхлүүлэхээр бүртгэлийг 2020 оны 05 дугаар сарын 07–ны өдөр эхлүүллээ.

Аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу Боловсрол, соёл урлагийн байгууллагуудад 2020 оны 05 дугаар сарын 14-15-ны хооронд 5 чиглэлд ажлын хэсэг ажиллаж нөхцөл байдалтай танилцаж зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгууллаа. Тус ажлын хэсгийн гишүүдээс байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө боловсруулан, батлан хэрэгжүүлж, гал унтраах иж бүрэн хэрэгсэл бүхий галын булан байгуулж галын аюулгүй байдлын самбар гарган ажиллах, цахилгааны мантажийн аюулгүй байдлын талаар холбогдох мэргэжлийн байгууллагаас заавар зөвлөгөө авч ажиллах, байгууллага бүр хариуцлагатай жижүүр томилон ажиллах чиглэлийг өгч, авч хэрэгжүүлэх арга хэмжээг заавар журмын дагуу үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэл өглөө.

Жаргалант сумаас зохион байгуулсан “Бидний хот ногоон хөгжил” аян, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас өрнүүлсэн “Хог биш Мод таръя” хөдөлгөөн, “Ногоон хот” хөтөлбөрийн хүрээнд 9 ажлыг уялдуулан ажлын төлөвлөө гарган ажиллаж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: Дэлхий дахинд тархаад буй “Ковид-19” халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор “Ковид-19 халдварт цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ” сэдэвт улсын хэмжээнд зохион байгуулсан дадлага сургуулилтын дагуу аймагт зохион байгуулж Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Зооноз өвчин судлалын

төв болон мэргэжлийн ангийн нийт 131 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэнийг оролцуулж, “Ковид-19” халдварт цар тахлын үед үзүүлэх тусламж үйлчилгээ, үйл ажиллагааны төлөвлөлт, авч хэрэгжүүлэх арга хэмжээний зохион байгуулалтыг хэрхэн төлөвлөх, мэдээ мэдээллийг хэрхэн хүргэх талаар мэдлэг, дадлага хослуулсан арга хэмжээг төлөвлөн гүйцэтгэлээ.

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, 7 төрлийн хорт хавдрын үзлэг шинжилгээнд хамруулах хүмүүсийн судалгааг гаргаж, 2020 онд зорилтот бүлгийн нийт 56790 иргэд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдахаар байна.

Эрүүл мэндийн сайдын 201 дүгээр тушаал, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан журам, зааврын дагуу цочмог сул саажилтын тандалт судалгааг Жаргалант сумын 1-5 хүртэлх насны эрүүл хүүхдийн өтгөний 40 сорьцыг авах ажлыг зохион байгуулан мэдээллийг Халдварт өвчин судлалын төвд хүргүүлээ.

“Тэмбүүг устгая” үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс тэмбүүгийн эрт илрүүлэг, үзлэгийн 14 хоногийн мэдээг сард 2 удаа авч нэгтгэн ХӨСҮТ-ийн БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тандалт судалгааны албанд хүргүүлэн ажилласнаас ХДХВ-ийн шинжилгээнд 8270, тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээнд 7953 хүн хамрагдаж эхний 4 сарын байдлаар нийт 85 тэмбүүгийн халдвартай хүнийг илрүүлэн 78 хүнийг эмчлээд байна.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн А/327 тоот тушаалаар батлагдсан “Тэмбүүг устгая” үйл ажиллагааг эрчимжүүлж, тэмбүүгийн илрүүлэг үзлэгийг нэмэгдүүлэх зорилгоор 14 сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд Монбио фарм ХХК-иас гэрээний дагуу ХДХВ, тэмбүүгийн халдвар илрүүлэх хавсарсан оношлуур 19012 ширхэг, өндөг цоологч 14790 ширхэгийг, Булган сумын Нэгдсэн эмнэлэгт 4000 ширхэгийг тус тус нийлүүлж илрүүлэг үзлэгийг зохион байгууллаа.

Эмзэг бүлгийн иргэдийг тэмбүүгийн үзлэг шинжилгээнд хамруулах зорилгоор Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 1,500,000 төгрөгийн дэмжлэгээр 730 ширхэг оношлуур худалдан авч 5 өрхийн эрүүл мэндийн төвд хуваарилан үзлэг шинжилгээнд хамруулахаар ажиллаж байна.

Тайлант сард дархлаажуулалтын дэлхийн өдрүүдээр товлолын вакцинжуулалтаас гадна сайн дурын вакцин болон тархвар судлалын заалтаар хийгдэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулж, В гепатитын эсрэг вакциныг 30 хүнд, галзуу өвчнөөс сэргийлэх вакцинаар 13 хүнийг дархлаажуулах арга хэмжээг авч дархлаажуулалтанд шаардлагатай 3 хөргөгч 30 ширхэг термометрийг Халдварт өвчин судлалын төвөөс авч хуваарилан олголоо.

2020 оны 4 дүгээр сарын байдлаар аймгийн хэмжээнд 139226 хүнд үзлэг хийсний 29508 буюу нийт үзлэгийн 21,1 урьдчилан сэргийлэх үзлэг эзэлж, 732 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 10-аар нэмэгджээ.

Нялхсын эндэгдэл 9 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөнд 12.3 промилль буюу өмнөх оны мөн энэ үеэс 5.6 промилээр, 0-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 11

тохиолдол буюу 15 промилль буюу өмнөх оны мөн энэ үеэс 5.7 промилээр тус тус буурсан байна.

Халдварт өвчний тохиолдол 4 дүгээр сарын байдлаар 238 тохиолдол буюу 10000 хүн амд 26.9 буюу өмнөх оны мөн энэ үеэс 2 продицемилээр буурсан ба халдварт өвчний 65,9 хувийг бэлгийн замаар дамжих өвчин, 10 хувийг сүрьеэ, 6,3 хувийг салхин цэцэг өвчин тус тус эзэлж байна.

Тайлант сард 0-2 насны хүүхдүүдэд өндөр тунт А аминдэмийг хуваарийн дагуу сум, өрхийн хүүхдүүдэд бүрэн олгож, витаминжуулах ажлыг хийлээ.

Эрүүл мэндийн яам, Сангийн яамнаас хамтран хэрэгжүүлж буй Ерөнхий гэрээний худалдан авалтын цахим дэлгүүр системд шинээр 34 нэрийн эм, 5 нэрийн эмнэлгийн хэрэгсэл нэмэгдсэн бөгөөд эдгээр эм, эмнэлгийн хэрэгслийн 2 дугаар улирлын захиалгыг хийж, 4 эм ханган нийлүүлэх байгууллагын 13 нэр төрлийн 18,8 сая төгрөгийн эмийг сумын нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвүүдэд түгээлээ.

Энэ оны 2 дугаар улиралд Эрүүл мэндийн газрын эмийн агуулахаар дамжуулан нийлүүлэгдсэн ерөнхий гэрээний худалдан авалтын 24 нэрийн эм, эмнэлгийн хэрэгслийг сумын нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвүүдэд нийлүүлж, эхний 4 сарын байдлаар нийтдээ 6 компанийн 69,3 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг эмийн агуулахаар дамжуулан эмнэлгүүдэд түгээсэн.

Жирэмсэн болон хөхүүл эхэд хэрэглэх олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийг нийлүүлэхээр шалгарсан Евро фарм ХХК-ны 9,7 сая төгрөгийн бэлдмэлийг сум, өрхийн 20 эрүүл мэндийн төвүүдэд хуваарилан олголоо. 2021 оны хөрөнгө оруулалтын судалгаанд Зооноз өвчин судлалын төв, Булган, Буянт өрхийн эрүүл мэндийн төвийн барилга, БОЭТ-ийн дагалдах барилгууд, Цэцэг сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга зэргийг хамруулахаар санал хүргүүлээ.

Корона вируст халдвар (COVID-19)-ын дэгдэлтийн үед дайчлагдан ажиллах эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтний судалгаа, Гамшгийн үед дайчлах суралцагч эмчийн судалгааг тус тус гарган өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын тушаалын дагуу хариуцлагатай жижүүрийг томилон мэдээллээр ханган ажиллаж байна.

Тав: Хяналт, шалгалт, үнэлгээ дотоод аудитын талаар: Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг сайжруулах ажлыг эрчимжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагаанд иргэд олон нийтийн оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам, Ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан “Ховд аймгийн төрийн байгууллагуудын цахим мэдээлэл ба ил тод байдлын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамж”-ийн дагуу 32 байгууллагын цахим хуудсанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлэв.

Үнэлгээнд хамрагдсан байгууллагуудын 56.3 хувь буюу 18 байгууллага албан ёсны цахим хуудас ажилуулж, байгууллагынхаа үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг тогтмол байршуулан, баяжилт хийж, иргэдэд мэдээ мэдээллийг тухай бүр мэдээлэн ажиллаж байна. Мөн үнэлгээний дүнгээр 8 байгууллага буюу 44.4 хувь нь хангалттай, 6 байгууллага буюу 33.3 хувь нь сайжруулах шаардлагатай, 4 байгууллага буюу 22.3 хувь нь хангалтгүй үнэлгээ тус тус авлаа.

Үлдсэн 43.7 хувь буюу 14 байгууллага Facebook pages болон Facebook хаяг ажиллуулж, зохион байгуулсан болон цаг үеийн ажлынхаа мэдээ мэдээллийг тухай бүр шуурхай байршуулж, иргэд, олон нийтийг мэдээ мэдээллээр ханган ажиллаж байгаа хэдий ч албан ёсны цахим хуудасгүй байгаа нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоолоор баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам” болон бусад холбогдох хууль, тогтоомжийг зөрчиж байна.

Иймд цахим хуудас ажиллуулж иргэдэд хүргэснээр үнэлгээ авах, алдаагаа хянах боломжтой болох төдийгүй бодитой, шуурхай, цэгцтэй, үнэн мэдээлэл нь иргэдийн төрийн үйлчилгээний байгууллагуудад итгэх итгэлийг сайжруулах тул үйл ажиллагааныхаа талаар болон шинэ дутам гарсан эрх зүйн актууд, тайлан, цаг үеийн мэдээ мэдээлэл зэргийг Монгол Улсын MNS 6285:2011 стандартын шаардлага хангасан, хуулиар хориглосноос бусад мэдээ мэдээллийг олон нийтэд ойлгомжтой, нээлттэй, ил тод байдлаар хүргэх албан ёсны цахим хуудас ажиллуулах талаар зөвлөж, зөвлөмж хүргүүлэв.

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-нд заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс Ховд аймагт холбогдолтой заалтууд болон Монгол Улсын хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Ерөнхий сайдын захирамж, албан даалгавар, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, хуралдааны тэмдэглэл, ЗГХЭГ-ын даргын тушаалыг www.unelgee.gov.mn сайтаас татаж, жагсаалт гарган сум, байгууллагуудад хүргүүлээд байна.

Мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэрийн жагсаалт гаргаж, хэлтэс, сум, байгууллагуудад албан бичгээр хүргүүлэв.

2020 оны 05 дугаар сарын байдлаар Засгийн газрын тогтоол 40, хуралдааны тэмдэглэл 8, албан даалгавар 1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол 109-ийг хүлээн авч хяналтын карт хөтлөн, аймгийн удирдлагуудад танилцуулан, удирдлагын заалтын дагуу сум, байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийн явцад хяналт тавин ажиллаж байна.